




ЯПОНЧУУД МОНГОЛЫН ТУХАЙ
モンゴルに関する日本人学者らの考察

ТУСГААР ТОГТНОЛ,
НЭГДСЭН МОНГОЛ УЛСЫН
ТУХАЙ МӨРӨӨДӨЛ
独立及び統一モンゴルへの夢



Улаанбаатар 2020

Ончуков 1980: А.П. Ончуков. Д.Сүхбаатар манай үйлдвэрт зочлон ирсэн. “Зөвлөлтийн анд нөхөд Д.Сүхбаатарын тухай” УБ., 1980.

Ринчино: (Э.Д. Ринчино) К истории панмонгольского движения и роли в нем Д.Ринчино. (未刊行) Кунгуров/Сорокиков 1957: Г.Кунгуров и И.Сорокиков. Аратская революция. Издание второе, исправленное и дополненное. Иркутск. 1957.

Сорокиков 1961: И.И. Сорокиков. Монгол-Зөвлөлтийн найрамдлын торгон эх. “Намын амьдрал” 1961.11.

Сорокиков 1965: И.И.Сорокиков. На заре советско-монгольской дружбы. “Материалы по истории и филологии Центральной Азии” Вып. 2. Улан-Удэ. 1965.

Сорокиков 1980: И.И. Сорокиков. Жанжин Сүхбаатар. “Зөвлөлтийн анд нөхөд Д.Сүхбаатарын тухай” УБ., 1980.

Сүхбаатар 1952: Д.Сүхбаатар. Захидал бичгүүд. УБ., 1952.

Үнэн 1990.3.1: Нийтлэгдээгүй баримт бичиг. “Үнэн” 1990.3.1.

ХЗНТ: Хүүхэд-залуучуудын нэвтэрхий толь. II. УБ., М., 1986.

Ширэндэв 1969: Б.Ширэндэв. Монгол ардын хувьсгалын түүх. УБ., 1969.

ЧҮЛТЭМ ДА ЛАМ ЭХ ОРНООСОО ДҮРВЭСЭН ҮҮ?

Камимүра Акира

Оршил

1930-аад оны эхээр Алтайн урианхайчууд бөөнөөр Алтай давж одоогийн Хятадын Шинжаан руу нүүж явсан. Энэхүү түүхэн үйл явдлын тухай 1990-ээд оны эхнээс “эх орноосоо дүрвэсэн” гэсэн ойлголт бий болжээ. Жишээ нь: Алтанхуяг (1991) “1930 онд Урианхайн хошууны захирагч да лам Чүлтэм тэргүүтэн нутгийн захиргааг шинэчлэн зохион байгуулаагүй болон Монголын хил хязгаар хамгаалагдаагүйг ашиглан Алтайг давсан нь Монголын нутгийн феодал ноёд, лам нар өөртөө татагдсан ард олныг хилийн чанадад дүрвүүлэх эхлэл болжээ” (р. 86), “..1930-1932 онд эх орноосоо дүрвэх (доогуур зураас зурсан КА) хөдөлгөөн их болсон нь зүүнтний нугалаатай холбоотойн дотор хамгийн гол нь хар шар феодалуудтай хийх тэмцэлд алдаа гарсан болон эрх ямбаа алдсан феодалуудын хор нөлөөнөөс болсон нь тодорхой юм” (р. 93), мөн сүүлийн үед Авирмэд (2012) “... зарим ухвар мөчид ард иргэд болон эд хөрөнгөө хураалгаж, хэргэм зэргээ хасуулсан лам, ноёд тэргүүлэн эх орноосоо дүрвэн гарах (мөн КА), бослого тэмцэл гаргахыг оролдох болсон нь улс орны дотоод нөхцөл байдлыг ихэд хүндрүүлсэн юм” (р. 7) хэмээн бичжээ.

Энэ хоёр зохиогч хуучин НАХЯ-ны архивын материалыг ашиглан энэ үйл явдлын тухай нэлээн дэлгэрэнгүй бичсэн. Тухайлбал Алтанхуяг (1991), “Зарим баримтыг дурдахад Урианхайн хошууны Давст нуур сумын ардууд цуурхал, хүчинд автагдан 1930 оны тавдугаар сарын 12-нд гэнэт бөөнөөр нүүдэллэн, улсын хилд дөхөн Түргэн хэмээх газар буугаад байсан үед ард олны дунд зургадугаар сарын 22, 23-ны өдрүүдэд чанад талаас,

Булган голын хөвөөнд 300 хасаг цэрэг довтлон ирж буудалласан гэнэ (НАХГ-ын Архив, Ф-1 Д-ЭТХ ХН-7 96 дахь тал) гэсэн цуурхал тарсан нь тэднийг дүрвэн нүүхэд хүчтэй нөлөөлсөн байна” (pp. 86-87) гэж энэхүү үйл явдал яаж өрнөснийг тодорхой бичсэн.


Монгол хэлний “дүрвэх”, “оргох” гэдэг үг түүхийн баримтуудад “санаа урван дүрвэсэн”, “төр засгаас урван дүрвэсэн” гэх мэт “урвах” гэдэг үгтэй цуг хэрэглэдэг сөрөг муу үнэлэмжтэй үг болно. Гэхдээ социализмын үед энэ “дүрвэх хөдөлгөөн”-ийн тухай хувьсгалын түүх буюу ангийн тэмцлийн үүднээс л авч үздэг байсан. БНМАУ-ын Түүх III, 1969, 289-р талд “Хар шар феодалын этгээд зүүний нугалаа завхралыг ашиглан зах хязгаар нутагтай Өмнөговь, Дорноговь, Дорнод аймгууд, ялангуяа Алтай, Ховд, хязгаарын ард түмнийг үймүүлэн, зарим хоцрогдонгүй хэсгийг хилийн чанадад оргуулан нүүлгэжээ” гэж бичсэн байдаг. 1930-аад оны эхээр Алтай урианхайчууд Алтай давсан нь “хувьсгалын эсэргүү”, тухайн үеийн “төр засгаас урван дүрвэсэн” үйл явдал байсан.

1930 онд Алтайн урианхайчууд Алтай давсан тухай “эх орноосоо дүрвэсэн” гэсэн ойлголт буй болсон нь тухайн үеийн (1990-ээд оны эхээр) улс төр, нийгмийн уур амьсгалтай шууд холбоотой. Дээр дурдсан Алтанхуягийн өгүүлэл (1991) “Түмний хараанаас мултраагүй” гэдэг номны нэг бүлэг бөгөөд УАХБ-ын (хуучин НАХЯ) хошууч генерал А. Думбурай, хурандаа Г. Дүйнхэржав нар “Оршил”-ыг нь бичихдээ “... улсыг аюулаас хамгаалах байгууллага бүхэлдээ буруу зөрүү ажиллаж, алдаа гаргаж ирсэн юм шиг туйлшрал үзэгдэх болж байна. ... Тийм ч учраас улсыг аюулаас хамгаалах байгууллагын улс нийгэмдээ гүйцэтгэсэн үүргийг тухайн үеийн нөхцөл байдалд нь бодит байдлаар авч үзэж зөв үнэлэх явдал чухал болон тавигдаж байна” (Алтанхуяг et al. 1991:9) гэж тус номыг хэвлэсэн учрыг дурдсан байдаг. Социализмын үед “хувьсгалт төр засгаас санаа урван дүрвэсэн” гэж байсныг “эх орноосоо дүрвэсэн” гэж өөрчилсөн шалтгаан энд тодорхой байна.

Гэвч “тухайн үеийн нөхцөл байдалд нь бодит байдлаар авч үзэж, зөв үнэлэх” юм бол “эх орноосоо дүрвэсэн” гэсэн үнэлэлт нь дараах асуултыг шууд үүсгэх болно. Үүнд: Алтай урианхайн Баруун гарын сул сайдын хошууныхан нутгаасаа зугтсан юм уу? Мөн энэхүү түүхэн явдлыг удирдсан гэж бичигддэг Чүлтэм да лам ямар үзэл санаатай байсан, чухам тус явдалд яаж оролцсон бэ?

Энэ асуултад Үндэсний Төв Архивын материал болон биеэрээ Алтай давсан нутгийн өвгөдийн ярианд тулгуурлан хариулах болно.

1. Алтай урианхайн баруун амбаны хошууны “эх орон” буюу “төв” нь хаана байсан бэ?



Зураг 1

Дөрвөдийн баруун аймгийн сул сайд гүн Балдандорж, гүн Галсанжав нарын долоон хошууны урианхайн харьяат нутгийн зураг.


Олноо өргөгдсөний 3-р он 10-р сарын 25-ны (1913) (Монгол улсын аймаг, хязгаар, харуулын нутгийн түүхэн хилийн зургийн Альбом. Улсын геодези, зураг зүйн газар. УБ. 1986:24)

Нэгдүгээр асуултыг “Алтай урианхайчуудын ‘эх орон’ буюу ‘төв’ нь хаана байсан бэ?” гэж тавьж болно.

Дээрх газрын зураг нь “Дөрвөдийн баруун аймгийн сул

сайд гүн Балдандорж, гүн Галсанжав нарын долоон хошууны урианхайн харьяат нутгийн зураг нэгэн хамт энэ” гэдэг гарчигтай Олноо өргөгдсөний 3-р он 10-р сарын 25-ны (1913) зураг юм. Энэ зураг долоон хошууны төв нь Шар сүм буюу одоогийн Шинжааны Алтай хотод байсан бөгөөд урианхайн нутаг нь баруун тийш Зайсан нуураас цааш Эрчис, Бөгтөрмаа хоёр голын наад газар цөм Алтай урианхайн нутаг байсныг харуулж байна.

Энэ зургийг Баруун сул сайдын хошуунд үйлдсэн гэж үзэж болох юм. Учир нь Зүүн сул сайдын тамга алга бөгөөд зөвхөн Баруун гарын сул амбаны хошууны тухай



Зураг 2

Зураг 1-ийн хар дөрвөлжин доторх хэсгийг томруулсан нь 149 Урианхайн гүн Балдандоржийн хошуу суух газар, 148 Эртний өвгөдийн бумба хүүрний газар, 154 Чингэл голын лам хүрээ, 153 Гүн суух газар

“Эртний өвгөдийн бумба хүүрний газар”, “Чингэл голын лам хүрээ” гэх мэт нарийн тайлбар бий (Зураг 2). Энэ хошуу буюу Балдандорж ноён, Чүлтэм да ламын хошууны “төв” болох эд газрууд бүгд Алтайн цаад тал Хойд ба Өмнө Чингэл голд байсан ажээ.

Доорх бичиг нь Дархан бэйсийн хошуунаас 1924 оны Улсын анхдугаар их хуралд хуудсаар (бичгээр) илтгэсэн “Алтай урианхай аймгийн Дархан бэйсийн хошууны олон ард нийтээс” гэж эхэлдэг илтгэл болно⁷⁴.

Язгуураас эдүгээ болтол манай урианхайн долоон хошууны нутаг газар завсартаа хуваасан хилгүй, холицолдон суусны дотор, (1) манай нэгэн хошууны их төлөв ба, тус аймгийн дундуур нь хойд Алтай Чингэл, Өрөнгө, Хирэн, Эрчис, Хав, Ханас, Алагбэг, Бэлчиг голуудын зэрэг олон тариалан, хадлан, ой мод, жимс тэжээл, үст, эвэрт ан гөрөөс зэрэг дэлхийн баялаг үлэмж газраа хоёр зуун илүү онд нутаглан суусан нь дэлхийн шим, ан гөрөөс зэргийг гол болгож амьдран идээшлийг олсон бөгөөд, бас ч урьд Чин улсын үед хар хасаг цутган орж ирснийг хаан эзний зарлигаар манай нутагт багтаан суулгаж жил бүр өвс бэлчээрийн хөлс тэмээ, адуу, үхэр, хонь тус бүр нэг зуугаадаас нижгээдийг хураан авч, бас хасаг тариа тарихад тариалангийн хөлсийг зүй зогсоор тусгай хураан авч ядууг тэнхрүүлэх ба, албанаа нийлүүлэн хэрэглэсээр нутаг газрын шимд түшиж аж төрөн алба залгамжилж он уджээ. Гэтэл (2) Чин улс мөхөж манай монголчууд тусгаар тулгар төрийг байгуулсан учраа шажин үндэс овог язгуураа эрхэмлэж нутаг үндсээр дагаар орохоор эрмэлзэн атал, Олноо өргөгдсөний гуравдугаар онд хоёр зуун илүү цэрэг очиж Өрөнгө, Чингэл, Чанхан зэрэг газраа суусан манай нэг хошууны ардуудыг тамга, захирлын хамт нэг мөсөн

⁷⁴ Тус хуралд Дархан бэйс Жамьянжавын хошууны (Баруун гарын сул сайдын хошуу) хүнд Сандаг, мөн жанжин Итгэмжит гүн Нацагдоржийн хошууны (Зүүн гарын сул сайдын хошуу) мэйрэн Тэвэгт нар төлөөлөгчөөр оролцсон юм (УТА 11-1-12). Жамьянжав нь Балдандоржийн ууган хүү, зүүн гарын гүн Галсанжав 1914 онд Алтай давсан учраас түүний төрсөн авга ах Нацагдорж ноён болсон.

шилжүүлэн нүүлгэсэнд даруй дагаж манай нутаг Булган, Дэлүүн, Сэнхэр зэрэг газраа нүүн хүрч ирээд нутаглан суусаар буй. Үүнд энэ газруудад тариалан, хадлан жимс тэжээлгүй бөгөөд, ой мод өвс бэлчээр, өвөлжөө, ан гөрөөс зэргээр нэн ховор тулд хавчигдаж тус хошууны ардууд жил бүр торгуудын нутаг Шархулсны зэрэг газраа нүүн орж өвөлжих ба, мөн Чингэл голын зэрэг газар цөөн өрх очиж мал бэлчээрлэн бага сага ан агнан тариа тарьж авчрах ба, арван дөрөвдүгээр он хүртэл тэрхүү нутаг газруудад суусан хасагуудаас өвс бэлчээр тариалангийн хөлсийг урьдын удааг мөрдүүлэн хураан авсаар асан бүлгээ. Одоо ойрноос хасаг этгээд газар тариалангийн хөлс өгч байтугай харьяат урианхай хасаг нэгэнт хоёр улсад хуваагдан дагасан тул энэхүү нутаг газар Хятадын харьяат газар болох учир ан үл агнуулмуй, тариа үл тариулмуй хэмээн хүчирхэхийн дээр хулгах, булаах зэргээр хохируулан гачигдуулж, ядуу нэгэн хошууны ардууд амьдралыг олох бэрхэд хүрч бүхүй нь байн байсаар тэрхүү нутаг газрыг бүрмөсөн гадаадад алдвал ер хүмүүжих аргагүй, тэр ч байтугай манай урианхай нутгийн баруун хойд хязгаар Оросын нутагт зах нийлсэн уудам их бөгөөд дэлхийн баялаг үлэмж боловч (3) цөм хятад, хасаг этгээд эзэрхэж ашиглан бүхий учрыг илтгэж, тэрхүү шим өнтэй нутаг газрыг дотоодод хамгаалан авч, ядуу урианхайн хэдэн хошууны ардуудыг хүмүүжүүлэн нутаг үндсээр бүрэн бүтэн болгож тэнхрүүлэхийг хүсмүй. Пунцагдорж бичжээ. 1924 он (ҮТА 266-1-1)

Илтгэлд өөрийн нутгийг “хойд Алтай” буюу Алтайн цаадах баялаг ихтэй газар мөн гэж танилцуулаад, Чин улсын үед хааны зарлигаар казахуудыг нутагтаа багтаан суулгасны тухай дурдсан байдаг (1).

Балдандорж ноён Чин улс мөхсөний дараа Олноо өргөгдсөний хоёрдугаар он зургаан сарын хорин найманд (1912) Богд хаанд дагаар орохыг хүссэн бичгийг (Зураг 5) өргөсөн байхад Алтайн наад талд ирсэн явдлыг тайлбарласан байна (2). Энд дурдсан хоёр зуун гаруй цэрэг нь Зарлигаар зарсан баруун хязгаарыг тохинуулах хэргийг хавсран туслагч байсан тайж Баярын цэрэг байсан.

Тайж Баярын Дотоод хэргийг бүгд захиран шийтгэх яаманд өргөсөн бичигт “манай хошууныг танхай хасаг нар хулгаад булаах ба хохируулан зовоох зэргийн олон учрыг хэлж биднийг хамгаалан авахыг гуйн мэдүүлсэнд сан ба торгуудын бэйс, гүн, хошоодын гүнгийн зэрэг гурван хошуунаас зуун илүү тэмээг тэсгэн гаргаж тэрхүү гүн Балдандоржийн харьяат лам хар ардыг цөмийг шилжүүлэн нүүлгэж Булган голд ирүүлж нутаглан суулгаж буй” (ҮТА АЗ-1-444:12; cf. Нямдорж 2006:143) гэсэнтэй нийцэж байгаа боловч тэд дуртай нүүж ирээгүй гэдэг нь дээрх 1924 оны илтгэлд тодорхой байна. Алтайн наад талд нүүж ирээд Дөрвөдийн баруун гарын Үнэн Зоригт хан аймагт хавсарсан билээ.

Энэ явдал нь “Хаант Орос, Хятадын хооронд 1912 оны эцсээр Бээжинд эхэлсэн хэлэлцээгээр бүх Өвөр Монгол ба Алтайн хязгаарын 10 хошууг Хятадын мэдэлд таслан авах”-аар (Цэдэн-Иш 2003:74) тогтоосонтой шууд холбоотой. Мөн 1913 оны 12 дугаар сарын 8-ны өдөр байгуулагдсан гал зогсоох протоколоор “Монгол, Синьцзяны хооронд байлдааны гал зогсоох шугамыг тогтоохдоо: Монгол Алтайн нуруугаар уруудаж Алтайн нурууны Ганц модны даваанд хүрээд, Булган голын гольдиролоор уруудан өмнө зүг чиглэн Цагаан түнгэ, Туханцэг, Хараатын ам хүртэлх шугамыг 8 сарын хугацаагаар” (Мөн ном:78-79) тогтоосон учраас Чингэл гол бол Шинжааны талд байсан ажээ.

Илтгэлийн сүүлд тэдний нутаг нь (3) “цөм хятад хасаг этгээд эзэрхэж ашиглан бүхүй учрыг илтгэж тэрхүү шим өнтэй нутаг газрыг дотоодод хамгаалан авч ядуу урианхайн хэдэн хошууны ардуудыг хүмүүжүүлэн нутаг үндсээр бүрэн бүтэн болгож тэнхрүүлэхийг үнэхээр эрмэлзэн хүсмүй” гэж хэлсэн юм. Алтайн урианхай, Торгууд, Казахын төлөөлөгчид улсын их, бага хурал дээр Алтайн цаадах нутгийг нь Монгол улсын мэдэлд оруулахыг хүссэн илтгэл удаа дараалан тавьдаг байжээ.

Алтайн цаадах урианхай, торгууд, казахуудыг наашаа татан нүүлгэх Монголын засгийн газрын бодлого 1924 онд БНМАУ байгуулсны дараа ч хэвээр байсан шиг байна. Улсын хоёрдугаар их хурал дээр Алтайн урианхайн

төлөөлөгч Тэвэгт “Алтай урианхайн 7 хошуу болбол эдүгээ хүртэл хятадын харгис ноёдын эрх мэдэлд дарлагдан зовж буй, гэтэл гадаад яамны сайд Гиваабалжираас тэдгээр урианхай нарыг татан авч дагаар оруулах явдлыг Хятад Монголын хооронд харилцан гэрээ батлаж тогтоосны хойно, сая шийтгэх хэрэг бөлгөө” хэмээсэн нь их л зохилдохгүй бөгөөд эдүгээ бидний урианхай нар харгисуудын талхинд тэсэхүйеэ бэрх болж буй тул энэ тухай улсын хоёрдугаар их хурлаас тодорхой заавар гаргаж шийтгэхийг их л хүсмүй” гэж хэлсэн байдаг (УИХ, УБХ 2009:103).

Улсын их, бага хурлын төлөөлөгчид засгийн газраас шаардаж байснаар засгийн газрын байр суурь бас өөрчлөгдөж эхэлсэн шиг байна. Мөн Чойбалсан нар Алтайн алтны уурхайд их сонирхож байсан (УБХ 2009:196-197). Нөгөө талаас Шинжаан мужийн байдал 1928 онд мужийн дарга Янь Цэншинь (楊增新) алуулсны дараа тогтворгүй болоод Зөвлөлтийн нөлөө ихсэх эхлэл болжээ. 1930 оны 4 сард хуралдсан Улсын зургадугаар их хуралд тавьсан төлөөлөгч Өлзий-Очирын асуултад Гадаад яам “Алтайн хязгаарын манай улсын хил болбоос Алтайн Шар сүмийн газраар боловч эртнээс нааш манж хятадын эзэрхэгүүдийн үед тэдний хот сая байгуулж цэрэг цагдаа суулгасан нь энэ завсар хараахан нэгдэх болоогүй учир, харьяат хасаг нар хоёр анги болж нэлээд бэрхтэй амуй. Иймд Хятад манай хоёр харилцаагүй тул одоо хэр гүйцэтгэхэд мөн ч эргэлзээтэй зүйл буй болов уу хэмээн түдгэлзсэн хэмээвч эцэст улсын нутаг үндсэнийг алдагдахгүй бодолхийлэн буй” (УТА 11-1-215, 40-р тал) гэж хариулсан байдаг.

Иймээс Алтайн урианхайн баруун гарын сул амбаны хошууны “эх нутаг” буюу “төв” нь Алтайн ар (цаад) талд байсан нь тодорхой бөгөөд 1915 оны Гурван улсын гэрээгээр Алтайн хязгаарыг Хятадад оруулахаар болсон ч БНМАУ-ын засгийн газар 1930 оны хувьд Алтайг Монголд авах саналтай байсан билээ⁷⁵.

⁷⁵ Ринчино үүнийг дэмжиж байсан (Базаров et al. 1998:34-38).

2. Тухайн үед Алтай урианхайчуудын хувьд БНМАУ-ыг “эх орон”-оо гэж үзэж байсан уу?

Алтай урианхайн тухайн үеийн байдлын талаар Улсын бага хурлын гишүүн Сурахбаярын⁷⁶ 20 дугаар он арван сарын хорин наймны өдөр (1930 он) буюу Чүлтэм да лам тэргүүтэй урианхайчууд Алтай давсны дараа Улсын бага хурлын тэргүүлэгчдэд өргөн мэдүүлсэн илтгэл тодорхой харуулж байна. Үүнд:

... Баруун хязгаарт явсны дотор эл баруун хязгаарын бага ястан, хасаг урианхайн доторх байдлыг авч үзвээс ...

1 Эл баруун хязгаарын хасаг урианхайн нутаг газарт гадаадтай тогтвортой тогтсон хил хязгааргүй ...

...

9 Гишүүн Өргөнжав, Даржаа, Эрхдаваа, лам Цоохор, Дамжаа нараас хэлсэн нь манай нутгийн хязгаар хаана, ямар газар буй, ямар газраар хязгааралмуй? Энэхүү нүүсэн айлууд тус улсын нутаг дотор нүүж байна уу, үгүй юү? Хязгаар нэвтэрч байх хэмээсэнд хязгаар давж нэвтэрсэн хэмээн хариулбаас мөн Өргөнжаваас хэлсэн нь Чингэл болбоос уулын язгуураас манай урианхайн нутаг болох тул тэрхүү нүүсэн айлуудын хойноос очиж уулзацгаамуй. Үнэмлэхгүй, бичиггүй шуудаар явмуй хэмээсэнд тийнхүү дур зоригоор үнэмлэхгүй хязгаар нэвтэрч үл болох учрыг хэлэхэд ер нь Чингэлд жил бүр тариалан тарьж амьдардаг манай урианхайн чухал амьдарлагын газар болох учир хэн хэрхэн хэзээ хэдний өдөр манай нутгийг хэн өгсөн. Харин саяхан нүүсэн айлууд болбоос нутгийн дотор нүүсэн хэмээх зэргээр хэлсэний дээр хасаг нар манай Монголын харьяат ахул нааш юунд эс буумуй. Үүнийг үзвээс манай нутагмөн биш үү? Харин халх нар хэнд өгсөнийг бид нар ер нь мэдэхгүй хэмээх зэрэг хэлсэн хэмээмүй.

⁷⁶ Тамжидын Сурахбаяр 1880 онд Алтайн урианхайн зүүн гарын сул сайдын хошуунд төрсөн. 1927 оноос бага хурлын гишүүн, 1928-1931 онд Дотоодын сайд, 1931 оноос Бага хурлын дэргэдэх Бага ястны зөвлөлийн ерөнхий нарийн бичгийн даргаар ажиллаж 1932 оноос Улсын бага хурлын дарга, 1939 онд хэлмэгдсэн. (УТА 11-1-273)

10 Танай нутагт тариалангийн газар байх эсэхийг асууваас манай тариалан тарьдаг газар Чингэл гол болно. Түүнээс өөр газар байхгүй. Одоо тэр газартаа тариа таримуй хэмээсэн ба басхүү гэр мал нь хязгаар нэвтрэн нүүснээс энд ганц бие нутагтаа хоцорсон хүмүүс байх тул эд нар ах дүү, эцэг эхтэйгээ үнэмлэх бичиггүйгээр гэртээ очиж болох эсэх. Хэрвээ болохгүй аваас ямар учраас болохгүй бол. Хэрвээ эд нарт үнэмлэх олгуулах аваас мөнгө авдаг буй заа. Ер нь юм бүгдэд мөнгө авч байдаг шүү хэмээн хэлсэн амуй хэмээжээ.

....

14 Мөнөө 2-оос хэлсэн нь танай халх нарын заавар дүрэм өдөр бүр солигдож байдаг. Бид нар алиныг дагах билээ. Ер нь хэрхэвч дагаж чадахгүй болсон шүү хэмээх зэргээр хэлсэн амуй хэмээхээ. ... (УТА 11-1-230)

Тус илтгэлийн 1-р зүйлд баруун хязгаарт Хятад-Монголын тогтвортой хил тогтоогүй байгааг дурдаад нутгийн хүмүүсийн яриаг танилцуулсан байдаг. Үүнээс харахад тухайн үеийн Алтай урианхайчууд улсын хилийн тухай огт ойлгоогүй байсан ба тогтворгүй ч гэсэн хил нь тэд нарын амьдралд их саад болоод байсан, мөн түүний улмаас засгийн газарт гомдолтой байсан нь тодрхой болно. 14-р зүйлд бас тэдний гомдол, засаг төр нь "халх нар"-ынх бөгөөд өөрийнх бус гэсэн ойлголт илэрхийлэгдсэн байдаг.

Миний бие Ховд аймгийн Дуут сумын өндөр настан Мэндбаяр (1919-1997) гуайгаас 1995 оны 11 сарын 25-нд энэ үйл явдлын тухай ярилцлага авав. Тэрбээр 1931 оны хавар Алтай даваад намар нь буцаж ирсэн юм.

Манайхан би 13 настай байхад манай нутгийн хошуу улааны ёсноос сална гэж. /Энэ юу гэсэн үг вэ? АК/ Үүнийг манайх мухар гэж байсан. Энэ мухрын ёсноос сална гээд. Бага насны хүүхдийг сургууль гэж аваачаад хорт могой тэжээнэ. Залуучуудыг цэрэг гэж аваачаад улаан орост алуулах гэж байна. Энд байж болохгүй. Хойно Шинжаанд сайхан газар бий. Үр хүүхэдтэйгээ тэнд очиж амьдарна гэж монголын феодал ноёд ард түмэнд ухуулга хийж байжээ.

Манайхны ухамсар муу болно. Үр хүүхдээс салахгүй, тэгээд Алтай давсан байна.

Энэ ярианд "мухар" гэдэг нь гэзгээ тайрсан, шинэ, хувьсгалт ёсыг дагагч хүмүүсийг хэлдэг. Тухайн үеийн Алтай урианхайчуудын хувьд халхчууд гэсэн үг байжээ. Тэд ардын хувьгалыг халхын "мухар ёс" буюу өөрийнх биш гэж ойлгож байсан.

Ер нь тэр үед "эх орон" бол Монгол мөн гэсэн ойлголт, ухамсар бүрдээгүй юм уу Монголын ард түмний дунд түгээмэл биш байсан. "Эх орон" гэдэг үг ч бараг хэрэглэгдээгүй байсан. Уг ойлголт нь 1930-аад оны хоёрдугаар хагасаас өөрөөр хэлбэл Япончууд Монголын дорнод хилд халдах үеэс бүрдэж эхэлж Халх голын дайны үеэр түгээмэл болсон (Камимүра 2010). Иймээс Алтайн урианхайчууд 1930 онд эх ороноос дүрвэж Алтай давсан биш, харин эх орондоо буцсан гэж хэлж болох юм.

3. Чүлтэм да лам ямар хүн байсан бэ?

Ном хэвлэлд Чүлтэм да лам тэргүүлэн ард түмнийг Алтай давуулсан гэж бичсэн байдаг. Жишээ нь Авирмэд



Зураг 3. Монголын автономит засгийг устгасны дараа Монголын 10 дугаар онд Хятадын сайд Сюй Шу Жан-гаас гадаад Монголын хойчийг сайжруулах хэргийг хэлэлцэн тогтоохоор Халх, Дөрвөдийн зэрэг газрын ноёдын хурлыг хуралдуулж буй зураг. [Л. Дэндэв. 2012 (1934). Монголын товч түүх. УБ. 268-р тал]

(2012:45) нэг баримтаас иш татаад, “Чүлтэм да лам нь нутгийн ардуудыг дагуулан хятадын зүг явсан”, Сүхбаатар (2000:67) “Урианхайн баруун хошууны Чүлтэм Да лам тэргүүлэн хошуу нутгийнхаа ард олныг авч Алтай давснаар” гэж бичсэн болно. Харин Ховд, Баян-Өлгий аймгийн урианхайчуудын яриа өөр байна.



Зураг 4.

Мөн Иргэн улсын 9-р оны (1920) 7-р сард Бээжинд орохоос өмнө Чуулалт хаалганд Чуулалт хаалганд сууж Цахарын хошууг захирагч сайд (察哈尔都统) Ван Тинчен (王廷桢)-тэй авхуулсан зураг. Жалханз, Дилав хоёр хутагтын ард зогсож байгаа Чүлтэм да лам. (cf. Lattimore & Isono 1982:101-103)

Чүлтэм да лам 1886 онд төрсөн, нохой жилтэй. Алтай урианхайн баруун гарын сул амбаны хошууны засаг ноён асан Балдандоржийн төрсөн дүү. 1915 онд Балдандоржийг нас барсны дараа үе залгамжилсан түүний ахмад хүү Жамъянжавын тамгыг хамаарсан. 1927 оноос бага хурлын гишүүн, мөн шинээр байгуулагдсан Алтай урианхайн баруун хошууны даргаар ажилласан.

Зураг 3 нь 1920 оны 8-р сард Бээжинд авахуулсан

Чүлтэм да ламын зураг болно. Жалханз хутагт тэргүүтэй Монголын төлөөлөгчдийг уригч Монгол, Төвдийн журганы (蒙藏院) ерөнхийлөгч Харчин ван Гүнсээноровын хажууд лам хувцастай суугаа нь Чүлтэм да лам. Доор нь “Дөрвөдийн Чүлтэм да лам” гэж тайлбар буй. Урьд Ховдын сайд, 1907 оноос Алтайн сайдад захирагдаж явсан Алтай урианхайн 7 хошуу нь 1912 онд Богд хааны Монгол улсад дагаар ороод Дөрвөдийн баруун гарын чуулганы Үнэн зоригт хан аймагт багтаан хавсрах болсон юм.

Гэвч Дилав хутагтын дуртгал (Lattimore & Isono 1982) дотор ч мөн Чэнь жагсаасан төлөөлөгч 17 хүний дотор ч Чүлтэм да ламын нэр байхгүй. Анх Монголоос сонгосон төлөөлөгчийн ихэнх нь лам хүн байсныг өөрчлөөд 12 ноёд, 4 ламыг дахин сонгосон юм (Чэнь 1922: III хэсэг, 17-19). Мөн нэр нь байгаа боловч Бээжинд очсонгүй хүн байсан тул жагсаалт нь төгөлдөр биш байж болно. Харин лам байсан Балдандорж ноён, Чүлтэм да лам хоёр Ховдын Шар сүмд удаан сууж ажилласан Жалханз хутагттай нягт холбоотой байсан. Тийм учраас анхны жагсаалтад Чүлтэм да ламын нэр байж Бээжинд хамт явах болсон байж магадгүй.

Зураг 5 нь 1912 онд Балдандорж ноён Богд хааны төрд дагаар орохыг хүссэн Батлан өргөх бичиг болно. Уг бичгийг Богд хаанд биш Р.Наваанцэрэн, Жалханз хутагт хоёрт өргөсөн юм. 1912 оны 6-р сард Р. Наваанцэрэнг Баруун хязгаарыг сэргийлэн батлах сайд, Жалханз хутагт Дамдинбазарыг зөвлөж хавсран шийтгэх сайдаар томилсон байжээ. (Мягмарсамбуу 2011:38)



Зураг 5

Балдандорж ноён Богд хааны төрд дагаар орохыг хүссэн батлан өргөх бичиг (УТА АЗ-1-444:12)

Батлан өргөх бичиг

Алтайн урианхайг захирагч баруун гарын бүгдийн дарга Балдандоржийн бичиг,

Зарлигаар зарсан баруун хязгаарыг сэргийлэн батлах сайд цэргийн хэргийг бүгд захиран шийтгэх яамны дэд сайд Зоригт бэйс, зөвлөн шийтгэх зарлигаар шагнасан Түгээмэл сайтай номун хан Жалханз хутагт танаа өргөв. Хүсэн батлаж мэдүүлэхүй нь манай халхчуудыг манж хятадын сайд түшмэлүүд дээдийг мэхлэн доордыг даралхийлэн хашруулан зовоосон бөгөөд манж хятад нар өөрөө төр самууруулсан учир, манай халх монголчууд бүгдээр зөвлөлдөн тусгай улс төр тулгар байгуулан тогтоохоор нэгэнт тогтож Очирдара богд Жавзандамба гэгээнийг хаан өргөмжлөн олон монголчуудаа амруулан шашин номоо бататгахуйг үүний урьд Жалханз хутагтаас ухуулан зарлан ирсэн бичгийг хүлээн авч наманчлан залбирч зөвлөлдөн гүйцэтгэхүйн завсар баруун хойд хязгаарын их монголын эрдэнэ бишрэлт засаг лам Дамбийжанцан морилон ирж, элдэв учрыг сэнхрүүлэн ухуулж ачлан унтсан мунхагийн харанхуй гэнэт сэргэж бүгдийн дарга Балдандорж миний харьяат

хошуу ба захирсан дарга Гомбожав, Очиржав нарын гурван хошууны шар хар олон даяар амар жаргахуйг хичээнгүйлэн хүсч Очирдара богд хааны тулгар төрд баярлан дагаар орж шашин номыг улмаар бататгаж нийтээр цэнгэлдэн баярлаж Богд эзний хүнд хишиг сургууль соёл хүртээхүйг гүнээ хүсэн батлах бичгийг гаргаж олдвоос сайд Зоригт байс, Номун хан Жалханз хутагт Танаа батлан мэдүүлээд толилон үзэж уламжлан айлтгаж бид бүгдийг авран энэрч гүйцэтгэн асран тэтгэмжлэх ажаамуу, үүний тул батлах бичиг өргөв. Олноо өргөгдсөний хоёрдугаар он зургаан сарын хорин найман. (УТА А141-1-5:8)

Энэ бичиг Алтай урианхайн Баруун гарын гурван хошууг төлөөлсөн бичиг бөгөөд Жалханз хутагтаас хүлээн авсан захиа, мөн Жа лам цэрэгтэйгээ Чингэлд очсон нь Богдын төрд орж “шашин номыг улмаар бататгаж нийтээр цэнгэлдэн баярлах”-ыг хүсэхэд их нөлөөлснийг харуулж байна.

1907 онд Ховдын хязгаараас салгаж байгуулсан Алтайн хязгаарыг 1919 онд Алтайн хязгаарыг Ашандао (阿山道) болгож Шинжаан мужийн харьяанд оруулжээ. Алтай урианхайчууд Гадаад Монголын автономитийг устгасны улмаар Ашандаогийн даоин-аас (道尹: дао-замын захирагч) захируулах болсон юм. Ингээд Монгол улс тусгаар тогтнолыг сэргээсний дараа Чүлтэм да ламын удирдлагаар долоон хошуу цөмөөрөө Хятадаас салж нэг чуулган болон Монгол улсад нэгдсэн юм. Үүний тухай Алтайн урианхайн зүүн гарын Зүтгэлт гүн Цагаанбилиг нарын бичигт:

Алтайн урианхайн зүүн гарын долоон зэрэг нэмсэн, найман зэрэг тэмдэглэсэн, түшмэдийн бичиг. Зарлигаар зарсан Ховд зэрэг газрыг тохинуулах төлөөний сайд жанжин Хичээнгүй баатар бэйл, Зарлигаар зарсан Ховдод сууж хэрэг шийтгэгч сайд Үнэн зоригт хан танаа өргөв. Өргөн мэдүүлэх учир, эдүгээ манай зүүн гарын нутагт бүхүй засаг түшмэд харилцан боловсрон зөвлөж мэхийж

хянаваас манай Алтай урианхайн долоон хошуу анх Монгол улсыг тусгаар байгуулах цагт Богд хааны гэгээн соёлд дагаар орж хүнд зузаан хишгийг хүлээн хүртэж, Дөрвөдийн баруун аймагт хавсарган захирагдаж асан бөлгөө. Хараахан цагийн самуунд Шинжаан мужийн Даоин-аас эзэрхэн захирсан зүйл буй боловч, дараа Гадаад Монгол улс төрийг нэгэнт уг хэвээр мандуулсан тухайд манай урианхайн баруун гарын бэйс Жамьянжавын тамгыг хамаарсан да лам Чүлтэмийн газраас урианхайн долоон хошууг Иргэн улсаас нэгмөсөн ангижруулан авч, тусгай газраа захируулахыг байлгаж, урьдын ёсоор болгон, хошуу сум хөрөнгийг тэгшлэн, аливаа алба залгамжлах чуулган болгож, хишиг хүртээхийг гуйж мэдүүлснээр үл барам, бидний хошууд мөн нэгэн адил санаа цутган дагасан бөгөөд, дараа эрх баригчдын хуралдаанд мөн да лам Чүлтэмийн мэдүүлсэн байдал төлвөөр тус тус чуулган болгохыг эрж мэдүүлсэнийг хурлаар зөвшөөрөн баталж харьяат хоёр гараас чуулганы дарга тохоох хүмүүсийг сонгон томилож мэдүүлээр жанжин сайдууд таны газраас удаа дараа шаардан тушаасан тухайд өргөн мэдүүлсүгэй. Гэвч гагцхүү баруун гараас шууд татгалзах даруй үгүй манай нэгэн гар бас ч бүрэн бүтэнгүйд хүлгэлзэн агсаар өчнөөн болов. Одоо манай урианхай нар хэдүй нэгэн аяс гүйцэтгэсүгэй, гэвч зарим нь ийнхүү огт шийдвэргүйд бидний засаг түшмэд бусдыг дуурайн аймшиггүй өршөөрлийг үтээрхэн их журмыг тасруулсан мэт болоход хүрч бүхүй учир айн барахгүй тул, арга буюу, дээдийн соёлд багтаан бусдын эзэрхэгийг үгүй болгон, эрх баригчдын хуралд батлан тогтсон ёсоор чуулганы даргын тамга олгуулж хишиг хүртээн үүрд амар түвшнээр төрүүлэхийг мөргөн гуйхаас гадна, чуулганы даргад манай зүүн гарын одоо нутагт бүхий Зүтгэлт засаг улсын түшээ гүн Цагаанбилэг сайд Итгэмжит засаг улсад туслагч гүн Нацагдорж, Зоригт засаг улсад туслагч гүн Санданжав нарын алинд тохоох ба, ер манай урианхай хошуудыг яахин бүрэн бүтэн болгохыг дээд газраас тогтоон шийтгэж дагаж явуулахыг чин хэмээн хүсэхийн тул учрыг гаргаж олдвоос төлөөний сайд жанжин бэйл сайд Үнэн зоригт хан танаа өргөн мэдүүлээд, гуйх

нь эл байдал дүрсийг байцаан толилж, хэнээр хэрхэн захиргаж яахин амар түвшин болгон тохинуулахыг тогтоон шийтгэж заан тушаахыг гуйсугай. Үүний тул өргөв. Олноо өргөгдсөний арван хоёр он (1922) найман сарын хорин нэгэн" (ҮТА 263-1-1)

гэж тэмдэглэсэн байдаг. Үүний дотор мөн Чүлтэм да лам тэргүүтэй баруун гар ба зүүн гарын хоорондох зөрчил илэрхийлсэн болно.

Чүлтэм да лам 1925 онд хошуунд нь Ардын хувьсгалт намын үүр анх байгуулагдахад гишүүнээр элсжээ. 1926 оны намын гишүүний бүртгэлд:

Алтай урианхай аймгийн Дархан бэйсийн хошуу дахь Ардын хувьсгалт намын 199-р үүрийн гишүүдийн бүртгэлийг товчлон хураангуйлсан хуудас (15 (1925) он 8 сарын 22-т, Булган голд) Монгол Улсын 16-р он 7-р сарын 27-н

...

Овог Нэр: Самбуу Чүлтэм

Нас: 41

Үе улирах тайж, язгууртан, лам

Ах сум, Ах арван

Анх үүр байгуулахад элсэж орсон

Булган гол дахь хүрээнд суумуй, тус үүрийн дэргэд

Гэр дотор гэргий нөхөр хүүхэд ба эцэг ураг төрөл хэд болох: 1

Булган голд хурал номын үйлсээр амьдармуй

Сургуульд явсангүй. Төвд ном мэдмүй. Монгол үсэг бага зэрэг төсөөлмүй.

Албан хэргээр Шиньжан мужид явсан, газрын байдал ба хэл бичиг мэдэхгүй

Өнчин бус, зүрх хөл өвддөг, эрэмдэг зэрэмдэггүй

Сахилга журмын чанар: дунд

Шалгасан гэгээрэл боловсрол: дунд

Хөдлөх хөрөнгө 2 бод, гэр хэрэглэлийн үнэ 100 янчаан. Үл хөдлөх хөрөнгөгүй. Доорд анги

Урьд тус хүрээний да лам бөлгөө, одоо хошууны тамга хамааран хэрэг шийтгэж буй. Цалин хэрэглэлгүй. (МАХН-ын Архив 3-2-74)

Тухайн үед тус хошуунд анх элссэн нийт 26 гишүүн байв. Түүнээс бичиг сайн мэддэг хүн ердөө хоёр байсан. Чүлтэм да лам гэргийтэйгээ хоёулаа, хоёрхон бодтой, Булган голын хүрээнд ном уншиж амь зууж байсан юм. Зүрх, хөл нь өвддөг байжээ.

Мөн 1928 оны бүртгэлд:

Баруун хязгаарын Алтай урианхайн баруун хошуун дахь ардын хувьсгалт намын нэг зуун ерэн есдүгээр үүрийн гишүүдийн арван наймдугаар оны дэлгэрэнгүй бүртгэл МУ-ын 18-р он 6 сарын 16-н

...

Самбуу Чүлтэм

Тайж, язгууртай, лам, эрэгтэй

Нас: 43

Амын тоо: 6

Ах сум, Ах арван

Монгол бичиг: төсөөлмүй

Бусад боловсрол: х

Намаас бус газрын гишүүн: х

Аливаа жинхэнэ сургууль явсан: х

Аль газар ямар алба хаах: тус хошууны дарга

Биеэр бодын тоо: 93

Бусад хөдлөх, үл хөдлөх хөрөнгө хогшлын бүгдийн үнэ төгрөг: 250

Энэ хоёр зүйлийн нийлсэн бүхийн тоо: 95

Гадаадын хэл бичиг: Төвд ном мэдмүй

Юуг гол болгон амьдрах: хурал номын үйлсээр

Тайлбарлах нь: энэ нь ач, гишүүн бус Жамьянжавтай хөрөнгө нэгтэй (МАХНА 4-2-457)

гэж байдаг. Энэ үед мөн хошууны даргаар ажиллаж байсан. Ач дүү Жамьянжавтай хамт нэг өрх болоод ам бүл нь 6, 93 бодтой болсон юм.

Намын гишүүн Чүлтэм да лам 17-р (1927) он 10 сард Алтайн урианхайн Дархан хошуунаас Улсын IV их хуралд төлөөлөгчөөр сонгогдоод (УТА 11-1-136, 54-р тал) илтгэл тавьсан (УИХ 2010: 144-245). Улмаар бага хурлын гишүүнээр сонгогдоод Ховдод буцаж ирж Бага хурлын

тэргүүлэгчдэд шинэ байгуулсан Алтайн урианхайн нэг хошууны даргаар сонгогдсоноо мэдэгдсэн захидал (18-р (1928) он 2 сарын 25) бичжээ. Үүнд:

Улсын Бага хурлын тэргүүлэгч бат холбоот халуун журмын олон нөхдийн амрыг эрж илгээв. Энэ хир элэгсэг журамт нөхдийн энхрий биес амархан бөгөөд, эрхлэн оролдсон аливаа үйлс таалалчлан засрагдсаар буйг дурдах юун, шууд итгэж баталбаас болмуй. Миний бие, эрхэм нөхдийн нийцтийсэн[?] царайд ёслон салж уг нутагт буцаж ирснээс нааш улс төрийн сүлдэд шүтэж эрхэм нөхдийн хамгаалалд итгэн залбирч суусаар бөгөөд онц болгон бүтээсэн зүйлгүй дэмий өдөр хоногийг хоосоор өнгөрүүлэн суун бүхүйгээс өөр эрхэм нөхөд танаа сонордуулах сонин гоё л юмгүй. Ганц манай урианхайн ардууд ёст журамт өршөөлт засгийн соёлд хэдийнээс бишрэн дагасан боловч уг соёлоос суртлыг танилцан огт мэдээгүйн улмаас элдэвт мунгинан байсан нь өнгөрсөн зун цаг дарга нарын хуралд аймгийн яамыг татаж бүгдээр нэгдэн нэг хошуу болохыг эрмэлзэн илтгэсний дараа үүнээр явуулахад орон газрын байдал олон ардын саналд огт нийлэлцэхгүй явдал гарч санаа хоёртон тохиролдох төлөвгүй болсон учир дээд газраас дахин саналыг авуулахаар тушаасныг эх татаж тус аймгийн зургадугаар хуралд баттайгаар хэлэлцэн тогтоож хуучин зүүн баруун гар хэмээн явсан дөрөв, гурван хошууг хуучны найрамдан явсан занг мөрдүүлэн сая сэдэвлэн гаргасан оновчтой саналд нь нийлүүлж хоёр хошуу болгон зохиож зохих газраа мэдүүлж батлуулан ёсоор болгож сая аймгийн яамыг татаж хоёр хошууны хэргийг дор бүрнээ цэгцлэн явуулах хэргийн дэвийг үүсгэн бүхүй зэрэг учрыг эрхэм нөхдөд илт толилсоор тул олонтоо нуршихыг хэмнэсүгэй. Өөрийн биеийн тухай өгүүлбээс олон ардуудын хуралд хэлэлцэж шинэ зохиосон нэг хошууны дарга сонгосныг өөрийн бие мунхаг бүдүүлэг сурч боловсорсон эрдэм боловсролгүй тэнэг хөдөө эл тушаалын хэргийг гүйцэтгэхэд туйлын бэрхтэй учрыг илтгэж өөр чадах хүнийг дахин хэлэлцэж сонгомуу хэмээн гуйсан боловч хөдөлбөргүй болгон уг хэргийг хүлээлгэжүхэй. Үүнд хянаваас энэрэнгүй өршөөлт эрхт

гэгээн засгийн эрдэм соёлд сүсүглэн залбирч нэгэнтээгүүт итгэмжит мэргэн эрхэм нөхдөө түшиж сар өдөр ч болов хүлээлгэсэн нэрд ор болон чармайн оролдох зүй мөн боловч тус хошууны нутаглан суусан газар орон уудам их, хүн ардын зан суртал мунхаг харанхуй хэдийгээр нам засгийн бодлого зорилгыг мэдсэн хирээр ухуулбаас шууд итгэн бишрэх ба, сүсүглэн дагачид маш цөөн. Энэ дээр өнцөг хязгаарын ойр зэргэлдэн суусад гадаад этгээд болох бөгөөд сайн муу холицолдон бүхүй газарт дүрэм зааврын доторхыг хөдөлгөн ухуулж туйлд хүрэхээс зөвхөн баримтлан захирах нь туйлын бэрх хэмээвээс хараахан худал өгүүлсэн хэмээн сонжигдох зүйлгүй хэмээлтэй амуй. Тийн хэмээвч Монгол үндэстэн нэгдэн нийлж, улс гэрийг байгуулан, гадаадын гар саварт атгагдсанаас салж тусгай бүрэн эрхийг нэгэнт олсон үест мунхаг би мөхөс оюуны хэрээр нэгэн санааг баримталж ардын гэгээн засгийн үзэл суртал, ард түмний эрх чөлөөг тэгш эдлүүлмүй хэмээсэн зорилго зэргийг таниулж, нутаг үндсэний хамт элэг нийлэн хүмүүжүүлэх явдалд хөл зогсохгүй бие амрыг бодохгүй зүтгэхийг туйлын зорилго болгон идэвхийлэхийг эрмэлзэн буй. Эл учрыг итгэсний гэрч болгон эрээчүүлж Улсын Бага хурлын тэргүүлэгч гишүүн итгэмжит халуун журамын нөхдийн зүг хандуулан дэвшүүлж өргөөд гуйх нь нэгэн төрөлд нэгэн эхийн хэвлээс хамт төрсөн бус боловч ард олны зол заяагаар бүтсэн улс гэр ба амн засгийн ач гавьяагаар марташгүй халуун журмын ах дүү бололцсон гүн тангарагаар баталж албан хэргээс эхлэн аж ахуйд хүртэл өчүүхэн тэнэгийг хэрхэн хүмүүжиж явахыг зүйл дараалан сургуулилан ухуулж гэрэлт захидлыг цаг үргэлж нэвтрүүлэн хайрлаж нүүр учирснаас илүү ёсоор журамлаж гүнээ итгэн биширч дагаж явахыг хүсч молхи захидал бариулагч мунаг гишүүн Чүлтэм үнэн. 18 он 2 сарын 25-наа (УТА 11-1-179, 17-р талд)

гэж бичсэн байжээ. Мөн Улсын XI Бага хуралд илтгэсэн илтгэлүүд ба асуулт хариулт, шүүмжлэлд (хурлын тавдугаар өдөр: 18-р (1928) он 6 сарын 6),

Тус газрууд ажил амьдрал ба эрдэм боловсролын зэргээс

хоцорсон бөгөөд одоогоор тийнхүү засч залруулсан хэмээх зүйлгүй, саянаас хөдөлгөн оролдохыг хичээн бүхүй боловч бичиг үсэгтэй хүмүүн ховор зэргээс их л гачигдмуй. Аливаа аж үйлдвэрийн тухай болбоос нутаг үндсийг Хятадын этгээдээс эзэрхэх бөгөөд энэ хэр тариалангийн зэрэг аж үйлдвэрийг үүсгэн оролдоодүй, харин харьяат хошууд бага сургууль нэг буй нь эрхбиш эрдэм боловсролд сайжрах буй заа. (УТА 11-1-159, 122-р талд)

гэж хошууныхаа хүндрэлтэй байдал, тухайлбал “нутаг үндсийг Хятадын этгээдээс эзэрхэх”, бичиг үсэгтэй хүмүүс ховор байгаа тухай дурдаад, бага сургуультай болсноо танилцуулжээ.

Чүлтэм да ламын тухай Мэндбаяр (1919-1997) гуай Чүлтэм да лам хүмүүсийг Алтай давуулаагүй, харин нутгийн эрх баригчид түүнийг хүчээр давуулсан гэж ярьдаг байсан. Үүнд:

Давахад бас ийм учир байна. Чүлтэм да ламыг энэ мухрын ёсон барьж аваачсан. Барьж аваачаад тэд мэдэж байжээ. Улстай давах гэж байгааг чи толгойлж давуулах гэж байна гэжээ. Чүлтэм да лам хэлжээ. Би толгойлж давуулах гэгүй. Ард түмэн тийм бодолтой байгаа юм гэжээ. Улаанбаатараас энд Монгол улсын дөрвөн чуулга байв. Нэг нь Баян-Өлгийн төвд байв. Эндээс хүүхэд тэнд очиж суралцдаг байв. Тэгэхэд Баян-Өлгий аймаг гэж байгаагүй. Улаанбаатарт Чүлтэм да ламыг аваачаад, ахар буу өгөөд орос савхин хувцас өгөөд, чуулгын тамгын орлогч даргаар явуулжээ. Чуулгын тамгын орлогчоор байж байгаад энд ирэхэд, манайхан давахад бэлэн болсон байв. Чүлтэм да лам ирээд, “Та нар буруу юм хийж байна. Давж болохгүй. Энэ мухрын ёсон чинь дэлхий дүүрнэ. Түүнээс тойроод, очих газар байхгүй. Та нарын давах буруу” гэхэд, “Таныг бид барьж аваад явна. Таныг орхимжоор тань хүлж аваад явна. Давна уу? Үгүй юү?” гэхэд, “Тэгвэл та нар мэдэхээс биш, над хэлэх үг үгүй” гэжээ. Тэгээд Чүлтэм да ламыг хүчээр монголын ноёд

барьж аваад давжээ. Энэ нутаг хоёр тасарч давсан. Эхний давалтаар Чүлтэм да ламыг барьж аваад явсан. Хоёр дахь удаа цэрэг авч ирээд үлдсэн нутгийг давуулжээ.

“Улаанбаатарт Чүлтэм да ламыг аваачаад ахар буу өгөөд орос савхин хувцас өгөөд чуулгын тамгын орлогч даргаар явуулжээ” гэдэг нь Авирмэд (2012:45) “Ховд аймаг дахь нууц ажилтнууд болох да лам Чүлтэм ...” гэж бичсэнтэй (Тагнуулын газрын архивт байгаа ямар нэг баримтыг ашигласан) нийцэх болов уу. 1928 онд Чүлтэм да лам Ховд аймгийн Намын хорооны томилолтоор Алтайн цаана хасагуудын дунд ажиллаж Шинжааны улс төрийн байдал, казахуудын байдлыг судлаад Улсын XI бага хуралд илтгэсэн (Ганболд 2020:44).

Мөн Ганболд (2020:47) “аман түүхийн мэдээгээр анх 1923 онд Булган голын Сайханд зусаж байхад Чүлтэм да ламыг МАН-хан баривчлан хоёр гарыг олсоор хүлж, морь унуулан явжээ. Удалгүй суллагдаж ирэхэд хүмүүс “Манай ноён да лам Равдан комиссартай хүж бариад иржээ” хэмээн ярилцах болжээ. ... Дараа нь 1927 оны намар Улаанбаатар хотод өвөлжөөд ирэхдээ лам хувцасаа сольж, улаан чисчүү халх дээл, орос гутал, бортгон малгай өмсөж, ахар буу зүүж “хувьсгалч” дүр орсон байсанд хүмүүс “Манай ноён да лам баруун хязгаарыг түвшитгэх түшмэл болжээ” гэцгээж, тэр сүсэгтэн олонд адис хүртээхээс дургүйцэж, ноёд баядыг айлд ороход үүдээ өргөн оруулж болохгүй, мориндоо мордоход түшиж, тулж хэрэггүй, урьдын ёс устана, Мухрын номонд орохоос өөр аргагүй” гэхчлэн ухуулж байсны хамт сумын занги, ноёдууд “Ноён лам халхад очоод нутгийнхаа толгойг ардын засагт эргүүлэхийг хичээнэ гэж амлаад орос хувцас өмсөөд, мухарт талтай болоод иржээ, Чингэлдээ нүүхээс өөр аргагүй” хэмээн ярилцаж байжээ” гэж бичсэн байдаг. Чүлтэм да лам халхын талд орж “хувьсгалч” болоод ирснээс болж нутгийн хүмүүс түүнд дургүй хүрсэн нь Алтай давах нэг шалтгаан болсон билээ.

1939 онд Чүлтэм да лам Үрэмчид нас баржээ. Шинжаан мужийн захирагч Шэн Шицай (盛世才) “монгол, хасаг, уйгур олон ноёдыг хуурч дуудаад хар гэрт түгжээд зовоогоод тэр дотор Чүлтэм да лам нас баржээ” гэж Чингэлийн урианхай нар ярьдаг (Ганболд 2020:53).

Чүлтэм да ламын тухай дүгнэхэд, 1925 онд намын гишүүнд элсээд, анх 1927 онд Улсын их хуралд төлөөлөгчөөр яваад, улмаар Бага хурлын гишүүн болсон. Мөн 1927 онд орон нутгийн шинэ захиргаа зохион байгуулагдаж, 7 хошууг 2 хошуу болгоход шинэ Алтай хан уулын урианхайн баруун хошууны даргаар сонгогдсон⁷⁷ (ҮТА 266-3-2). Тэрбээр нам засгийн бодлого зорилгыг нутгийн хүмүүст ухуулахыг үүрэг болгон ажиллаж байсан. Үүнийг нутгийн хүмүүс Чүлтэм да лам халхын мухар ёсонд автагдсан гэж дургүйцсэн юм.

Ер нь Чүлтэм да лам ард түмнээ Алтай давуулсан уу, аль эсвэл түүнийг нутгийн хүмүүс Алтай давуулсан уу гэдгийг одоо яг дүгнэхэд хэцүү боловч нам, засагт үнэнч байсан нь өндөр магадлалтай байна.

4. Алтай урианхайчууд Алтай давсан үйл явдлын үр дагавар

Алтайн урианхайн Баруун гарын хошуунаас эхэлсэн хил даван “дүрвэх хөдөлгөөн” Алтайн урианхайн Зүүн гарын хошуу, Ховдын торгууд, захчин, казах хошуудыг багтааж, улмаар Алтай, Өвөрхангай, Өмнөговь, Дорноговь, Дорнод зэрэг Хятадтай хил залгасан аймгуудад дэлгэрсэн. 1930-1931 оны хоёр жилд Ховд аймгаас Шиньжан руу “дүрвэсэн” нь Алтайн урианхайн 1106 өрх буюу 3300 хүн ам, торгууд 300-гаад өрх, захчин 228 өрх буюу 670 хүн ам, казах 2430 өрх буюу 9170 хүн ам, нийт 3900 орчим өрх, 13540 хүн ам болсон. Мөн 1930-1932 онд Алтай зэрэг дээр

⁷⁷ Нөгөө Алтай хан уулын урианхайн зүүн хошууны даргаар Тамжидын Сурахбаяр сонгогдсон.

дурдсан аймгуудаас Хятад руу дүрвэсэн хүн амны нийт тоо нь арваад мянгад хүрсэн гэсэн тооцоо бий (Алтанхуяг 1991: 87-89). Тухайн үед БНМАУ-ын хүн ам 700 мянга хүрээгүй байсан учраас энэ нь тухайн үеээр их тоо байсан юм.

Алтайн урианхайн Баруун гарын хошууныхны хувьд өөрийн нутгийн дотор, төв рүүгээ нүүж буцсан энэ үйл явдал халхчуудын хувьд хувьсгал, төр засгаас урван дүрвэсэн хэрэг байхад, тухайн үеийн нөхцөл байдлаас зовон явж байсан бусад нутгийн ард түмэн, ялангуяа Хятадын хилд ойр нутагладаг Өмнөговь, Дорноговь, Дорнод аймгуудын хүмүүсийн хувьд “эсэргүүцэх хэлбэр” (a form of resistance) гэж тод харагдаад “дүрвэх хөдөлгөөн” улсын хэмжээгээр хүчтэй өрнөх болсон юм.

Мөн 1930 оны 7 сарын 10-нд бага ястны улс төр, эдийн засаг, соёлын ашиг сонирхлыг хамгаалах зорилготой Бага хурлын дэргэдэх “Бага ястны зөвлөл” байгуулагдаад 1932 оны 7 сарын 1-н хүртэл ажилласан (Болдбаатар 2009:253). Нарийн бичгийн даргаар нь Алтай урианхайн зүүн хошууны Сурахбаяр томилогдсон байна.

ДҮГНЭЛТ

Алтай урианхайн Баруун гарын сул сайдын хошууныхан, мөн бусад зургаан хошууныхан 1930-1931 онд Алтай давсан үйл явдал бол нутгаасаа дүрвэж зугтсан хэрэг биш байна. Тэднийг хувьсгалаас зайлсан гэж хэлж болох боловч, орон зайн хувьд Алтайн ар (цаад) талд байсан “эх нутаг” буюу тэдний “төв” рүү нүүж буцсан юм.

Тухайн үеийн Алтайн урианхайчуудын хувьд БНМАУ халхын “мухар ёс”-ны төр байж тэднийхээ “эх орон” биш байжээ. БНМАУ өөрийн эх орон мөн гэдэг ухамсар улсын хэмжээгээр ч цөөнх хүмүүст л байсан нь тодорхой. Мөн орчин үеийн улс (nation-state) -д амин чухал болдог улсын хил ч гэсэн бодитойгоор ч, ойлголтоор ч бүрдээгүй байсныг баримтууд харуулж байна. Тэд 1913 оноос хойш ч

“нутгийнхаа дотор нүүж” жилдээ нэг бус удаа Алтай давдаг байжээ. Тухайн үед “эх орон” бол Монгол гэдэг ойлголт ховор байжээ. Ардын төр засаг Алтай хязгаарыг Монголдоо эргүүлэн авахаар шийдсэн ч тэдний аж амьдралыг тохинуулах амласандаа хүрээгүй байсан. Иймээс тэднийг “эх орноос дүрвэсэн” гэвэл буруу, харин өөрийн нутаг болох “эх орондоо” буцсан болно.

Чүлтэм да ламын хувьд тухайн үеийн бичиг баримт, нутгийн хүмүүсийн аман яриаг үзлээ. Тэрбээр шинэ цаг үеийн уур амьсгалыг мэдэрсэн хязгаар нутагт ховор сэхээтний нэг байсан билээ.

Чүлтэм да лам МАН-д өөрийн хүсэл зоригоор элссэн, бичиг үсгийн өндөр боловсролтой хүн байсан тул хошуу дарга болсон байна. Харин түүнийг УАХ байгууллага Шинжааны байдлыг тагнуулахаар ашигласан эсэхийг тодруулах шаардлагатай.

НОМ ЗҮЙ

Авирмэд, Д. (2012) *Дүрвэх хөдөлгөөн ба улсыг аюулаас хамгаалах байгууллага -1930-1934 он-*. Тагнуулын ерөнхий газар, Тусгай архив. УБ.

Алтанхуяг, А., Амарсайхан, У., Банзрагч, Б. Баттулга, Ж., Думбурай, А., Цэрэнбалжир, Д. (1991) *Түмний хараанаас мултраагүй*. УБ.

Алтанхуяг, А. (1991) Дүрвэгсдийн хөдөлгөөн, In: Алтанхуяг et al. 1991: 84-109.

Базаров, Б.В., Цибилов, Б.Д., Очиров, С.Б. eds. (1998) *Элбек-Доржи Ринчино о Монголии*. Улан-Удэ.

Болдбаатар, Ч. (2009) БНМАУ-ын Бага хурлын дэргэдэх байгууллагууд. *Acta Historica Mongolica*, 10-33: 252-258.

БНМАУ-ын Түүх III (1969) УБ.

Ганболд, М. (2020) *Ховд аймгийн Дуут сумын түүх (МЭ VII-XXI зууны эхэн үе)*. УБ.

Жамсранжав, Дилав хутагт (1991) *Ар Монголын улс төрийн дүртгэл*. УБ.

Камимүра, А. (2010) 「国土・国境・国民：戦争の想像力—「祖国」防衛戦争としてのハルハ河戦争—」 (Territory, Borders and Nation: Imagination of War –The Battle of Halhagol as a Defence War for ‘Motherland’). In: Junko Imanishi and Husel Borjigin (eds.), *International Academic Symposium in Ulaanbaatar, Mongolia “The Battle of Khalkhyn Gol (Nomonham Incident) in the World History --Knowing the Past and Talking of the Future—”*. pp.519-530, Fukyosha: Tokyo.

Камимүра, А. (2015) Алтайн урианхайчууд эх орноосоо дүрвэсэн үү, эх нутагтаа буцсан уу? -1930 онд Алтайн урианхайчууд Алтай давсан нь. In: Сүхбаатар, На., Бямбажав Х.(eds.), *Bibliotheca Oiratica* LI: 98-110.

Lattimore, O. and Isono, F. (1982) *The Diluv Khtagt -Memoirs and Autobiography of a Mongol Buddhist Reincarnation in Religion and Revolution*. Asiatische Forschungen, Band 74. Otto Harrassowitz.Wiesbaden.

Монгол улсын аймаг, хязгаар, харуулын нутгийн түүхэн хилийн зургийн Альбом (1986) Улсын геодези, зураг зүйн газар. УБ.

Мягмарсамбуу, Г. (2011) Төр, цэргийн нэрт зүтгэлтэн, домогт жанжин Ардын Хатан Баатар С. Магсаржав (1878-1927 он). УБ.

Нямдорж, Б. (2006) *Ховдын хязгаар (1911-1919 он)*, УБ.

УБХ (2009) БНМАУ-ын анхдугаар бага хурлын хуралдаан (1924-1925), *MONUMENTA HISTORICA MONGOLORUM* 5(1-3), УБ.

УИХ, УБХ (2009) *Улсын хоёрдугаар их хурал, Улсын нэг, хоёр, гуравдугаар бага хурал, УБ.*

УИХ (2010) БНМАУ-ын дөрөвдүгээр их хурал, *MONUMENTA HISTORICA MONGOLORUM* 6(1), УБ.

Сүхбаатар, На. (2000) *Баруун хязгаарын нийгэм-улс төрийн хөгжлийн түүхэн тойм (XX зууны эхэн үеэс 1930-аад он)*, УБ.

Цэдэн-Иш, Б. (2003) *БНМАУ-ын хил үүсч тогтсон түүхэн тойм*. УБ..

Чэнь Чон-Цзү (陳崇祖) (1922) 『外蒙古近世史』 (Гадаад Монголын орчин үеийн түүх), 商務印書館.